



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
АЛБАН ДААЛГАВАР

2018 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Ой, хээрийн гал түймрээс урьдчилан
сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай

Улсын хэмжээнд 2017 онд 13 аймгийн 70 сум, нийслэлийн 5 дүүрэгт нийт 225 удаагийн ой, хээрийн гал түймэр гарч, 120.9 мянган га ой, 466.5 мянган га хээр, нийт 587,4 мянган га талбай түймэрт өртөж, иргэд, аж ахуйн нэгжийн өмч хөрөнгөнд 77.7 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Түймрийн нөхцөл байдлыг 2016 онтой харьцуулахад түймэрт хүний амь нас эрсдээгүй, түймэрт өртсөн эд материалын хохирлын хэмжээ, түймэрт өртөж шатсан талбай буурсан боловч, түймрийн тоо 63 хувь, байгаль, экологид учирсан хохирол 5.3 дахин тус тус өсчээ.

Цагдаагийн байгууллага 2017 онд гарсан 225 удаагийн ой, хээрийн гал түймрээс 156 удаагийн гал түймрийн хэргийн материалыг шалгаж, 4 материалд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, хохирол хуульд заасан хэмжээнд хүрээгүй, хүний санаатай үйлдлээс үүссэн нь тогтоогдоогүй, байгалийн үзэгдэл аянга, хуурайшилт зэргээс шалтгаалан 152 удаагийн гал түймрийн мэдээллийг зөрчлийн бүртгэлд бүртгэж 31,6 сая төгрөгийн хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлж ажилласан байна.

Цаг уур, орчны шинжилгээний газраас 2018 оны 3, 4, 5 дугаар саруудад нийт бүс нутгаар хуурайшилт эрчимтэй явагдаж ялангуяа ой, хээрийн гал түймрийн эрсдэл өндөртэй Сүхбаатар, Дорнод аймагт 0.5-1.5 градусаар, Архангай, Булган, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл аймгуудын нутгаар 0.5-1.0 градусаар олон жилийн дунджаас илүү халж, хур тунадас багатай гэсэн цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээлэл ирүүлсэн нь эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Иймд ой, хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангаж, гал түймэр унтраах зохион байгуулалтыг эртнээс сайжруулах, бүх шатны төрийн болон төрийн бус байгууллага, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ДААЛГАХ НЬ:

Нэг. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цэрэнбатад:

1.1. Ой, хээрийн гал түймэр гарах эрсдэл өндөртэй аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороодод Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Ойн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулиуд, Монгол Улсын Засгийн газрын 2013 оны "Журам жагсаалт шинэчлэн болон шинээр батлах тухай" 106 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулан ажиллах;

1.2. Хавар, намрын хуурайшилтын улирал 03 дугаар сарын 20-ноос 06 дугаар сарын 10, 09 дүгээр сарын 20-ноос 11 дүгээр сарын 10-ны хооронд болон зуны хэт халалтын үед Цаг уур, орчны шинжилгээний газраас ой, хээрийн гал түймрийн голомт, тархалтын зураг, хуурайшилтын мэдээг шуурхай боловсруулан Онцгой байдлын ерөнхий газарт хүргүүлж, мэдээлэл солилцох, хамтран ажиллах, цаг агаарын болон ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдлын талаарх мэдээллээр холбогдох байгууллага, хүн амыг хангах;

1.3. Орон нутаг дахь ойн анги, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг, иргэдэд ой, хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө туслалцаа үзүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих, сургаж дадлагажуулах ажлыг зохион байгуулах;

1.4. Ой, хээрийн гал түймрийн хуурайшилтын "аюултай", "нэн аюултай" зэрэгт хүрсэн үед Цаг уур, орчны шинжилгээний газрын цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагаанд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, үүлэнд зориудаар нөлөөлөх пуужингийн нөөцийг бүрдүүлэх, тэдгээрийн аюулгүй ажиллагаа, хадгалалт, хамгаалалтанд хяналт тавих;

1.5. Ой, хээрийн гал түймрийн аюултай үед тухайн бүс нутгийн түймрийн аюулын ангилал, зэрэглэлийг үндэслэн аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт байгаль орчинтой харьцах үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хязгаарлах, хууль хяналтын байгууллагуудтай хамтран хэрэгжилтэнд хяналт тавих, холбогдох хууль, дүрэм, журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд авсан арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлэх;

1.6. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор ойн арчилгаа, цэвэрлэгээ, нөхөн сэргээлт хийх, хамгаалалтын шороон болон ойн зурвасыг сэргээх, шинээр нэмж хийх, усан сан, цөөрөм байгуулах ажлыг зохион байгуулах;

Хоёр. Аймаг, нийслэлийн Засаг дарга,

Онцгой комиссын дарга нарт:

2.1. Хавар, намрын хуурайшилтын улирал 03 дугаар сарын 20-ноос 06 дугаар сарын 10, 09 дүгээр сарын 20-ноос 11 дүгээр сарын 10-ны хооронд болон зуны хэт халалтын үед ой, хээрийн гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гарсан гал түймрийг илрүүлж, шуурхай мэдээлэх, унтраах зорилгоор ойн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтран эрсдэл өндөртэй бүс нутагт хөдөлгөөнт эргүүл, хяналт шалгалтын цэг ажиллуулах, иргэд болон байгаль хамгаалагч нарын оролцоотой урамшуулалт морин эргүүлийг зохион байгуулах, алслагдсан суурин айл, өрхүүдийг урамшуулах хэлбэрээр мэдээ, мэдээлэл тогтмол авах;

2.2. Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-д заасны дагуу ой, хээрийн гал түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө, шаардагдах төсвийг батлуулан хэрэгжилтийг хангуулах, биелэлтэнд хяналт тавих, хил орчмын болон орон нутагт гарсан ой, хээрийн гал түймрийн үед нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүйгээр хүч хэрэгслийг татан оролцуулж шуурхай унтраах ажлыг зохион байгуулах;

2.3. Галын аюулгүй байдлын тухай хуулийн 10 дугаар зүйл 10.2.4-т заасныг үндэслэн Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийг байгуулах, ой, хээрийн гал түймэрт дайчлагдан ажиллах хүн хүч, техник хэрэгслийг тооцон, тэдгээрийг гал түймэр унтраах багаж, техник хэрэгслээр хангах;

2.4. Нутаг дэвсгэрийн онцлогт нийцүүлэн ой, хээрийн гал түймэр унтраахад дайчлах гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийг ой, хээрийн гал түймрийн үед үүрэг гүйцэтгэх дадлага, чадвартай болгох дадлага, сургалтыг зохион байгуулж, албажуулах;

2.4. Ой, хээрийн гал түймрийн эрсдэл өндөртэй газар нутагт түймэр тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хийгдсэн хамгаалалтын шороон болон ойн зурвасуудыг сэргээх, шинээр нэмж хийх;

2.5. Бүх шатны Засаг дарга нар Ойн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.17, 17 дугаар зүйлийн 17.2.18-д заасан хугацаанд болон зуны хэт халалт, хуурайшилтын "аюултай", "нэн аюултай" зэрэгт хүрсэн үед ойн сангаас мод бэлтгэх, ойн дагалдах нөөцийг ашиглах, аялал зугаалгаар явах болон бусад үйл ажиллагааг хязгаарлах захирамж гарган хэрэгжилтэнд хяналт тавьж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилах;

Гурав. Батлан хамгаалахын сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Н.Энхболдод:

3.1. Тусгай чиг үүргийн нислэг үйлдэх нисэх онгоц, нисдэг тэрэгний техникийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж, хүн хүч, техник хэрэгсэл хүрэлцэн очих боломжгүй алслагдсан ой, хээрийн бүсэд гарсан гал түймрийн нөхцөл байдал хүндэрсэн тохиолдолд Улсын онцгой комиссын даргын тушаал, шийдвэрийг үндэслэн нисэх онгоц, нисдэг тэрэг ашиглан гал түймрийн голомтод бие бүрэлдэхүүнийг шуурхай хүргэх, ой, хээрийн гал түймрийг агаараас унтраах, орчин үеийн шинэ технологи хэрэгслийг ашиглах, сургалт дадлагыг Онцгой байдлын байгууллагатай хамтран зохион байгуулах;

3.2. Төв, орон нутгийн Зэвсэгт хүчний анги, байгууллагын бие бүрэлдэхүүнд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр Онцгой байдлын газар, хэлтэстэй хамтран хичээл, сургалт, дадлагын ажлыг зохион байгуулж, шаардлагатай техник, багаж хэрэгслээр хангах;

3.3. Хуурайшилтын аюултай, нэн аюултай зэрэгт хүрсэн үед Онцгой байдлын ерөнхий газартай хамтран эргүүлийн нислэг хийх, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу зэвсэгт хүчний алба хаагчдыг ой, хээрийн гал түймэр унтраах ажилд оролцуулах, бие бүрэлдэхүүнийг шаардагдах техник, багаж хэрэгслээр хангах;

Дөрөв. Улсын онцгой комиссын гишүүн, Хил хамгаалах

ерөнхий газрын дарга, хошууч генерал Ц.Сэргэлэнд:

4.1. Онцгой байдлын ерөнхий газартай хамтран хил орчмын ой, хээрийн гал түймэртэй тэмцэх чиглэлээр сургалт зохион байгуулж, бие бүрэлдэхүүнийг шаардагдах техник, багаж хэрэгслээр хангах;

4.2. Монгол улсын хил орчим гарсан ой, хээрийн гал түймрийн мэдээллийг Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Онцгой байдлын ерөнхий газарт шуурхай мэдээлж хамтран ажиллах, гарсан гал түймрийг цаг алдалгүй унтраах, арга хэмжээг зохион байгуулах;

4.3. Монгол Улсын хилийн бүс, хил орчмын нутаг дэвсгэр, хөрш зэргэлдээх орнуудын хил дамнан гарсан ой, хээрийн гал түймрийг унтраах, түймрийн тархалтыг таслан зогсоох, үйл ажиллагаа явуулах үед хоёр улсын томилгоот албан хаагч,

иргэдийг хярбаршуулсан журмаар хил нэвтрүүлэх асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;

4.4. Хил дамнан орж ирсэн болон хил давж гарсан ой, хээрийн гал түймрийн талаарх мэдээллийг тухай бүр Улсын онцгой комисс, Онцгой байдлын ерөнхий газарт албан бичгээр хүргүүлж баримтжуулах;

Тав. Улсын онцгой комиссын гишүүн, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа С.Баатаржавт:

5.1. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын даргын хамтарсан тушаал объектын болон ой, хээрийн гал түймрийн үед хамтран ажиллах журмыг хэрэгжүүлэн ажиллах;

5.2. Ой, хээрийн гал түймрийн хэргийн эзэн холбогдогч, шалтгаан нөхцөлийг тогтоож, хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авч энэ тухай холбогдох мэдээллийг улирал бүр Улсын онцгой комисст ирүүлэх;

5.3. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор төв, орон нутгийн ногоон бүсэд зорчих иргэд болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих, орон нутгийн төр захиргааны байгууллагатай хамтран байнгын болон хөдөлгөөнт хяналт, шалгалтын цэг ажиллуулах;

5.4. Ой, хээрийн гал түймрийн талаарх дуудлага, мэдээллийг хүлээн авсан тухай бүр төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагатай хамтран мэдээ, мэдээллийг харилцан шуурхай солилцож, хамтран ажиллах.

Зургаа. Улсын онцгой комиссын орлогч дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Т.Бадралд:

6.1. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах, сургалт сурталчилгаа явуулах, дадлага сургалтыг аймаг, нийслэлийн төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээд, иргэдийн оролцоотой зохион байгуулах;

6.2. Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, авран хамгаалах, унтраах ажлыг нэгдсэн удирдлага, бодлого, зохион байгуулалтаар хангах;

6.3. Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын нийт бие бүрэлдэхүүний ой, хээрийн гал түймэр унтраах, автомашин, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах;

6.4. Ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрсэн үед мэргэжлийн анги, албад, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг, нутгийн иргэдийг татан оролцуулах, тэдгээрийг мэргэжлийн удирдлагаар хангаж шаардлагатай тохиолдолд дайчилгаа явуулах;

6.5. Ой, хээрийн гал түймрийн голомтод олон хоног, удаан хугацаагаар ажилласан үед албан хаагчдын өдөр тутмын болон хөдөлмөр хамгааллын хувцасны эдэлгээний хугацааг харгалзахгүй нөхөн хангалт хийх;

Энэхүү албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж, мэдээ тайланг Улсын онцгой комиссын ажлын албанд 2018 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлэхийг холбогдох комиссын гишүүд, дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД,
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА



Ө.ЭНХТҮВШИН